

# ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ



## ТЕХНОЛОГИЙГ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ: ХҮНИЙ ЭРХЭД ШИНЖЛЭХ УХААНЫ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ НЬ ТӨСӨЛ

### ТОВЧ АГУУЛГА

#### ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

“Хүний эрхэд шинжлэх ухааны үзүүлэх нөлөө” (өмнө нь “Хиймэл дагуул ба хүний эрх” нэртэй байсан) 2008-2012 оны хооронд хэрэгжүүлсэн туршилтын төсөлт бөгөөд гол зорилго нь технологийн хүний эрхэд үзүүлж буй нөлөөг тодорхойлоход чиглэгдсэн юм. Хиймэл дагуулын газар зүйн мэдээллийн системийг ашиглан дэлхий нийтэд тулгамдаж буй хүний эрхийн зөрчлүүдийг илрүүлэх, илүү үр нөлөөтэй нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, технологийн хүний эрхэд үзүүлэх эерэг нөлөө, шинжлэх ухааны дэвшилийг тодотгоход чиглэсэн. Сансырын газарзүйн судалгааны ажилдаа радарын төхөөрөмж, өндөр нарийвчлалтай хиймэл дагуулын дүрслэл, агаарын гэрэл зураг, гео-дүрслэлийн багаж, гео зураг, GPS-ийг ашигласан юм.

Төслийг Америкийн Шинжлэх Ухааны Дэвшлийн Нийгэмлэг (AAAS), АНУ-ын Эмнести Интернэшнл, Эмнести Интернэшл (ЭИ)-ийн Олон Улсын Нарийн Бичгийн Дарга Нарын Газар (ОУНБДНГ) хамтран хэрэгжүүлж, “OAK” сангаас санхүүжүүлжээ. Төслийн буюу Шинжлэх Ухаан Хүний Эрхийн Төлөө (ШУХЭТ) багийг Эмнести Интернэшнл байгууллагаас томилжээ.

Үнэлгээний ажлыг ОУНБДНГ-ын Үр нөлөөг үнэлэх хэлтсийн мэргэжилтэн Хелен Нэлсон, Александра Хернандез Морэно нар ШУХЭТ төслийн багийн гишүүдийн тусламжтайгаар хийж гүйцэтгэжээ. Үнэлгээний үндсэн зорилго нь юун түрүүнд ЭИ-ийн явуулсан зорилтот ба зорилтот бус үйл ажиллагааны аль нь хамгийн илүү үр дүнтэй байсныг тогтоох, цаашид үргэлжүүлэх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад сансырын газар зүйн технологийн үзүүлэх ач холбогдлыг тогтоох юм. Үнэлгээний үр дүнг ЭИ-ийн ажилтан, ОУНБДНГ, хамтрагч наарт мэдээлэж, дадлага туршлагаа хуваалцах, цаашидын үйл ажиллагаанд ашиглах болно.

#### АРГАЧЛАЛ

Үнэлгээний ажил 2010 оны 10-р сараас 2011 оны 4-р сар хүртэл үргэлжлэхдээ нэн түрүүнд төслийн 2008 оны 1-р сараас 2011 оны 3-р сар хүртэлх хугацааны үйл ажиллагаа, ахиц дэвшилийг анхаарсан байна. Үнэлгээний аргачлал дараах үе шатаас бүрдэнэ. Үүнд

- Үйл ажиллагаанд хамрах хүрээ, зорилго, үнэлгээний аргачлалыг нарийвчлан боловсруулж тусгасан.
- Төслийн өөрчлөлтийн онолыг дахин боловсруулж, үнэлгээний ажилтнууд болон ШУХЭТ багийнхны амжилтыг үнэлэх шалгуур тогтолцоог дээшлүүлсэн байна. Төслийн өөрчлөлтийн онолыг “Өөрчлөлтийн цар хүрээ” хэмээн танигдсан ЭИ-ийн дотоод өөрчлөлтийн онолд тулгуурлан боловсруулжээ.
- ШУХЭТ багтай хамтран төслийн үндсэн оролцогч талуудыг тодорхойлж, гуч гаруй удаагийн ганцаарчилсан ярилцлага хийж, анхаарах асуудлыг хэлэлцэн дүгнэсэн байна. Боловсруулсан бичиг баримтуудыг дахин хянаж, хяналтын тайлан, хэвлэлийн судалгаа болон бусад холбогдох баримт материалыг ЭИ-ийн цахим хуудсанд байршуулжээ.
- Үнэлгээний ажилтнууд үр дүн, төслийн явцад хэвлэлийн бүхий л мэдээллийг харгалзан ажилласан болно.


#### ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Томоохон зөрчил, мөргөлдөөнтэй газруудыг хамарсан газарзүйн ялгаатай 15 туршилтын төслийг З жилийн хугацаатай хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд Өмнөд Осети/Гүрж улс, Чад, Дарфур, Эритрия,

Пакистан, Сомали, Шри-Ланк, Киргызстан, Нигер улсыг тус тус хамруулсан байна. ШУХЭТ төслийн баг зайлшгүй шаардлагатай төслүүдийг шалгаруулсан боловч, тэтгэлэгийн үндсэн шаардлага (иргэний болон улс төрийн эрх, олныг хамарсан хүчирхийлэл, албадан нүүлгэлт, нууц хорих газар)-д нийцэгүй тул төслүүдийг буцаажээ.

Үнэлгээний ажилтнууд өөрчлөлтийн онолд тусгагдсан үзүүлэлт, зорилтот хэсгүүдээр хийгдсэн ажлыг үнэлэн үр нөлөөтэй, амжилттай ажилласныг шинжлэн тогтоожээ. Туршилтын төслүүд дэвшил гарган, тавьсан ихэнх зорилтдоо хүрсэн болохыг нотолжээ.

- Төсөл хүний эрхийн зөрчил гарч байгааг үр дүнтэйгээр илрүүлэн амжилттай нотолж чадсан бөгөөд хариуцлага тооцохыг уриалахад хувь нэмрээ оруулж, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа өрнүүлэхэд хувь нэмрээ оруулсан юм. Зарим төслүүд ялангуяа Дарфур, Чад, Шри-Ланкад үр дүн гаргасан. Чад улсын хувьд албадан нүүлгэлт болон ойг тариалангийн талбай болгон цэвэрлэх ажлуудыг зогсооход хувь нэмрээ оруулсан юм.



• Технологийн тусламжтайгаар Нигер, Египет, Чад зэрэг орнуудад албадан нүүлгэлт, харин Сомали, Пакистан, Умард Осети, Киргызстан, Шри Ланк, Дарфурт олныг хамарсан хүчирхийлэл, албадан нүүлгэлт зэрэг зөрчлүүдийг илрүүлсэн байна. Одоогоор баттай биш ч гэсэн Эритрия дахь хэд хэдэн нууц хорих газрыг илрүүлэхэд ихээхэн тус болжээ. Дээрхи технологийн бас нэгэн давуу тал нь ЭИ-ийн очиж мэдээлэл цуглуваждахгүй байгаа нутаг дэвсгэрүүдээс шаардлагатай мэдээллээ олж авахад ашиг тусаа өгсөн. Мөн иргэний дэд бүтэц сүйтгэснийг тоолох, энгийн иргэд рүү халдсан зөрчлийг баримтжуулах, хүний эрхийг зөрчигчид, зэр зэвсэг, албан болон албан бус оршуулгын газруудыг тогтоох хяналтын чадавхийг нэмэгдүүлсэн бөгөөд хянах боломжийг бий болгож өгсөн.

- Хүний эрхийг зөрчиж буй үйлдлүүдийг харуулсан хөдлөшгүй баримт нотолгоогоор хангахаас гадна ЭИ-ийн явуулж буй нөлөөллийн үйл ажиллагаа, таниулан сурталчлах кампанит ажлуудыг ялангуяа дүрслэлийн хэлбэрээр хүргэхэд дэмжлэг болсон. Үйл ажиллагаанд, ярилцлага зохион байгуулагчид сансарын газарзүйн технологиор авсан мэдээлэл, дүрснүүд хөдөлшгүй баримт болж, хүчтэй нөлөөлөл үзүүлсэн бөгөөд ЭИ-ийн үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулсныг онцолсон юм. Эдгээр технологиор дамжуулан авсан дүрснүүдийг ашиглах нь маргаангүй давуу талтай билээ.
- Түүнчлэн төхөөрөмжүүд энгийн иргэд рүү халдсан цаг хугацааг тодорхойлох, иргэний дэд бүтцэд учруулсан хохирлыг илрүүлж албан ёсны тоо баримтаар ханган цаг хугацаа алдахгүйгээр олон улсын шударга ёс тогтоох үйл явцыг илүү үнэ цэнэтэй болгоход ач тусаа өгчээ.
- Үүний зэрэгцээ сансарын газарзүйн төхөөрөмжүүдийг ашигласнаар ЭИ нэр хүнд, итгэл үнэмшилээ хадгалж үлдэхэд, хүний эрхийн тэмцлийн тэргүүнд байж, түүний хэрэгжилтийг хянаж, цаг ямагт чанартай судалгаа, эерэг үр дүнг мэдээлсээр ирснийг улам баталсан билээ.

• Төслийн өөр нэгэн зорилго нь хүний эрхийн ажилтнуудын дунд, ялангуяа ОУНБДНГ-т шинжлэх ухааныг хүний эрхэд эерэг өөрчлөлт гаргахад ашиглах соёлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн байжээ. ШУХЭТ багийн бүрэлдэхүүн ажилтнуудад зориулж тусгай сургалтууд явуулсан. Энэ сургалтанд ЭИ-ийн өөрийн болон бусад байгууллагын өмгөөлөгч, судлаачдыг хамруулсан нь цаашид технологийн чадвар, мэдлэгтэйгээр хүний эрхийн асуудалд хувь нэмрээ оруулахад тус нэмэртэй хэмээн үзжээ.

Үнэлгээний явцад ОУНБДНГ-ын Африк, Европ болон Төв Азийн хэмжээнд хэрэгжүүлдэг хөтөлбөрүүд нь технологийн ойлголтыг илүү тусгасан, АНУ-ын ЭИ-ийн ШУХЭТ багт асар их нөөц туршлага байгааг тодорхойлсон байна.

Хэдийгээр АНУ-ын ЭИ болон ОУНБДНГазар хоорондын харилцаа үр бүтээлтэй, ач холбогдолтой боловч, үнэлгээгээр дараах зөвлөмжийн дагуу ажлаа сайжруулахыг анхааруулжээ. Үүнд:

- Талуудын аль нь дээрх туршилтын төслийн талаар эерэг сэтгэгдэлтэй байсан ч, амжилтын гол үндсэн тулгуур нь ШУХЭТ төслийн багийн зүгээс үзүүлсэн туслалцаа, идэвхи зүтгэл байсныг онцлон тэмдэглэмээр байна. ОУНБДНГ-ын ажилтнууд болон ШУХЭТ баг хоорондын үл ойлголцол, дүрснүүдийн чанарын талаар асуудал гаргах зэрэг зарим нэгэн тохиолдол үүссэн. Үүнээс хараад, хүний эрхийн шинжээчийнхээ хувьд дүрснүүдэд тайлбар, дүрсийг хүүрнэх өгүүлээмж зэргийг ашиглах боломжийг бүрдүүлж, зохицуулах тогтолцоо бий болгох хэрэгтэй гэдэг нь тодорхой байлаа. Тогтолцоог талууд төсөл өхлэхээс өмнө тодорхой хугацаанд харилцаан зөвшилцөн, эцсийн шийдвэрээ гаргахад мөн зохицуулалт хийх нь зүйтэй.
- Мөн үнэлгээний багийн дүгнэснээр төслийн менежмент сайжирсан байна. ОУНБДНГ-ын ажилтнууд болон АНУ-ын ЭИ болоод ШУХЭТ баг хоорондын харилцаан хариуцлагыг, төслийн зорилго тодорхой эсэх зэргийг хянах, тодорхойлоход бэрхшээлтэй байсан ажээ. АНУ-ын ЭИ ба ОУНБДНГ-ын ажилтнууд эхний шатны хяналтын тогтолцоог бий болгох болон харилцаан хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсноор хяналтын болон үнэлгээний ажилд шаардагдах мэдээллийн нөөцтэй болох ба эерэг өөрчлөлт хийх боломжтой болох юм.

## **ХҮНИЙ ЭРХИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ**

Үнэлгээгээр эдгээр технологи ЭИ-ийн нөлөөллийн ажлыг илүү дэвшилттэй болгосныг тогтоосон. Гэвч сансарын газар зүйн төхөөрөмж, хэрэгсэл болон аргачлалыг тус тусад нь бус харин төсөл, кампанит ажил тус бүрт шаардагдах арга арга зүйг цогцоор нь ашигласан бөгөөд энэ нь арга хэрэгсэл тус бүрийн үзүүлсэн үр нөлөө, хувь нэмрийг тодорхойлоход хүндрэлтэй болгосон байна.

### **ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ**

Сансарын технологи нь ЭИ болон бусад байгууллагуудын лобби, нөлөөлөл, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд тус болж Шри Ланкид албадан нүүлгэлтэнд өртсөн ойролцоогоор 300,000 иргэн нэгдэж эрх чөлөөний хөдөлгөөн өрнүүлэхэд нь хувь нэмэр үзүүлсэн байна. Түүнчлэн үнэлгээнд Чадад өмнө нь газраа чөлөөлөх эрсдэлд өртөж байсан хотын хэсэгт албадан нүүлгэхээс урьдчилан сэргийлэхэд төслийн болон олон нийтийн оролцоо чухал байсныг дурьдсан байна.

### **ХАРИУЦЛАГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ**

Төслийн салшгүй нэг бүрэлдэхүүн нь лобби, нөлөөллийн ажлууд байснаас гадна сансарын газар зүйн хэрэгслүүд ч өөр, өөр түвшинд хувь нэмрээ оруулсан байна. тухайлбал:

- Шри Ланкиас ирүүлсэн судалгааны үр дүнг АНУ-ын Төрийн Департмент тухайн орны дайны гэмт хэргийн талаархи илтгэлдээ тусгасан ба бусад ТББ-уудад хүргүүлсэн байна. Хэвлэл мэдээллийн эх сурвалжаас харвал АНУ-ын Төрийн Департамент Шри Ланкийн засгийн газрыг арга хэмжээ авах талаар шахалт үзүүлж байгаа хэмээсэн байна.
- Гуржийн зөрчилдөөний талаархи тайланг Европын Холбооны Зөвлөлд танилцуулсан ба шинжээчид ШУХЭТ төслийн багийн бүрдүүлсэн материал, хиймэл дагуулын дурсний шинжилгээний талаархи илтгэлээс хэд хэдэн удаа иш татсан байна.
- ОУНБДНГ болон АНУ-ын ЭИ-ийн ажилтнууд хиймэл дагуулын дүрсийг АНУ-ын засаг захиргааны зарим байгууллагуудад шууд нөлөөлөх ажилдаа хэрэглэсэн байна.

Мөн түүнчлэн төслийн хүрээнд шударга ёсноос зугтаж, хүний эрхийн зөрчлийг үгүйсгэх, санаатайгаар нуух болон ял шийтгэлээс мултарч үлдэх үзэгдэлүүдийг зогсоохыг зорьсон ба дараахи үр дүн гарчээ. Үүнд:

- Туршилтын төсөлд хамрагдсан ОУНБДНГ-ын цөөн хэдэн ажилтан төсөл өөрөө дангаараа хүчтэй нотолгоо гаргах боловч Шри Ланкийн хувьд ЭИ бүхий л үйл ажиллагааны хүрээнд хариуцлагатай байдалд уриалахад анхаарсан гэжээ. Зарим нэгэн оролцогчдын дүгнэснээр Кыргызстаны тохиолдолд сансарын газар зүйн зураглал хүмүүсийг хариуцлагатай байхад уриалж чадсан гэж үзсэн байна.
- Үнэлгээнд оролцогчдын ихэнхи нь сансарын газрын зурган дээрхи дурс, нотолгоонууд хэдийгээр зөрчлийг бүрэн зогсоох хэрэгсэл болоогүй ч ялангуяа Шри Ланкийн тохиолдолд хариуцлагатай байдалд уриалж, хариуцлагатай байдлыг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзсэн байна.

Мөн үнэлгээгээр төсөл зөрчлийг илрүүлэх нөхцлийг нэмэгдүүлж, өөрчлөлтөнд дуудсан уриалгыг өсгөсөн эсэхийг шалгасан байна. Үнэлгээгээр ШУХЭТ төслийн гаргасан сансарын газар зүйн бүтээгдэхүүн, дүрснүүд асуудлыг шийдвэрлэх, хэвлэл мэдээллийг оролцуулахад үзүүлсэн нөлөөний талаар санал хуваагдсан байна. Эдгээр дурс нь яаралтай шийдвэрлэх асуудлуудтай тохиолдолдыг энгийн аргаар дамжуулсан үр дүнгүй гэж үзэх байхад зарим оролцогчид дүрснүүд хэвлэл мэдээллийнхний анхаарлыг татахад нөлөөлсөн гэж үзсэн байна.

- Шри Ланкад хэрэгжүүлсэн төслийн явцад цуглуулсан баримт мэдээлэл хэвлэл мэдээллийн анхаарлыг хандуулахад Английн ЭИ-ийн хувьд үнэмлэхүй үүрэг гүйцэтгэсэн байна. Тэдний өгүүлснээр уг асуудлаар хэвлэлийн анхаарлыг татахыг оролсон боловч амжилт мутай байсан ба хиймэл дагуулын дүрснүүдийг тэдний анхаарлыг татах гол хэрэгсэл болгосон байна.
- АНУ-д хэвлэл мэдээллийг өргөн хүрээгээр хамарсан байна. АНУ-ын мөн олон улсын хэд хэдэн хэвлэлийн хэрэгслээр энэ талаар дурдсан байжээ. Ройтерс агентлагийн Гурж-Өмнөд Осетийн зөрчилдөөний тухай нийтлэл New York Times сонинд болон АНУ-ын Хүмүүнлэгийн, Хүний эрхийн тэргүүлэх мэдээллийн портал цахим хуудсанд нийтлэгдсэн байна.
- Чадад дурс зурагнууд хэвлэлийн анхаарлыг татах гол хэрэгсэл болсон ба олон арван мэдээлэл, нийтлэл гаргасан байна.

### **ИДЭВХИТЭЙ БАЙДАЛ БОЛОН ХӨДӨЛГӨӨНҮҮДЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ**

Эдгээр төслийн үр дүнд гарсан идэвхитэй байдлын өөрчлөлтийг үнэлж, дүгнэхэд бэрхшээлтэй байсан. Учир нь онлайнаар болон салбарын хэмжээнд явуулсан үйл ажиллагааны тоо хязгаарлагдмал байсан юм. ОҮНБДНГ дээр ярилцлаганд хамрагдсан ажилтнуудын цөөн хэд нь төслийн шууд нөлөөгөөр нэмэгдсэн кампанит ажил болон идэвхитэй байдлын талаар тайлagnаж чадсан бол зөвхөн хэдхэн секцүүд асуудалд хэрхэн хандсан болон идэвхитэй байдлын талаар мэдээлсэн байна. Гэсэн хэдий ч ШУХЭТ багийнхан үйл ажиллагаа нэн ялангуяа АНУ-ын ЭИ-ийн явуулсан кампанит ажлыг харьцангуй үр дүнтэй хянасан байна.

- Чадын төлөөх цахим үйл ажиллагаанд 30,000 гаруй иргэд нэгдэж, гарын үсгээ бүртгүүлжээ.
- Шри Ланка дахь албадан нүүлгэлт болон олон улсын хууль, дүрмүүдийг зөрчиж буй талаархи гарын үсэг цуглуулах аянд 70,000 гаруй хүмүүс хамрагдажээ. ШУХЭТ баг “Дэлхийгээ Нээлттэй Байлгая” онлайн үйл ажиллагаанд 35,000 гарын үсэг цуглуулсан байна. Харин дэлхий даяарх бусад ЭИ-ийн сец, салбаруудаас 40,000 гарын үсэг цуглуулжээ. Мөн түүнчлэн ШУХЭТ баг НҮБ-ыг олон улсын хянан шалгах ажиллагаа зохион байгуулахад уриалсан ажиллагаанд 50,000 гарын үсэг цуглуулжээ.
- “Пакистаныг харах нүд” болон бусад төсөлд зориулж нээсэн дагалдах цахим хуудсанд гурван удаагийн цахим үйл ажиллагаа зохион байгуулжээ. АНУ-ын ЭИ Пакистаны баруун хэсэгт иргэний хамгаалалтыг сайжруулах, баталгаажуулах талаар АНУ-ын Засгийн газрыг уриалсан хөдөлгөөнүүд болон үйл ажиллагаанд сансарын газар зүйн мэдээллийг ашигласан байна. Тус онлайн хүсэлтэнд нэгдэж дунджаар 13,000 хүн гарын үсэг зуржээ.

Ийнхүү үнэлгээний үр дүнгээс ажиглавал сансрын газар зүйн технологи кампанит ажлууд болон идэвхитэй байдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхийг баталсан байна.

### **ЗӨВЛӨМЖ**

#### **ТӨСЛИЙН/АСУУДЛЫН/УЛСУУДЫН СОНГОЛТ БА ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

- Төслийг илүү стратегийн ач холбогдолоор нь сонгох: Стратегийн ач холбогдол бүхий сонгогдсон төслүүдийн хүний эрхэд илүү ач холбогдолтой тогтвортой байдлыг нь харгалzan үзэх. ЭИ-ийн бусад төслүүдтэй харьцуулахад сансарын газар зүйн хэрэгсэл ашигласан ажиллагаануудын давуу тал ба ач холбогдолыг сайтар үнэлж байх, цаашид мэдээллийн эх сурвалж болгон ашиглах.
- Кампанит ажлууд болон хэвлэл мэдээлэлд сансарын газар зүйн хэрэглэгдэхүүнийг нэвтрүүлэх: Мэдээллийг өргөн цар хүрээг хамарсан хэвлэл мэдээлэлд ашиглаж болно. Илүү үр дүнд хүрэхийн тулд гол, гол кампанит ажлуудын бэлтгэл шатанд хэрэгслүүдийг ашиглахаар төлөвлөх шаардлагатай. Харин дүрснүүдийн хэрэглээ болон тэдний ашиглалтын давтамжийг анхаарах хэрэгтэй. Хэвлэлийнхний анхаарлыг хандуулахын тулд дүрснүүдийг зөв оновчтой сонгох нь чухал.
- ЭИ-ийн уламжлалт аргуудыг үргэлжлүүлэн хэрэглэх: Нотлох, хөндөхөөр зорьж буй тухайн сэдвээсээ хамааран сансарын газар зүйн дүрсийг оновчтой ашиглах нь зүйтэй. Ихэнхи тохиолдолд ЭИ-ийн уламжлалт газар дээр нь хийгдсэн судалгааны үр дүнтэй уялдуулж баталгаат, үнэн зөв мэдээлэл болгон ЭИ-ийн нэр хүндийг нэмэгдүүлэх.
- Төлөвлөлттэй нийцүүлэх: ШУХЭТ баг төслийг төлөвлөх, боловсруулах ажилд илүү оролцох, улмаар багийн төслийн бүрэлдэхүүн, цагийн хувиарлалт болон хэрэгжилтийн төлөвлөгөөнд оролцож, хангалттай мэдээлэлтэй байх. ШУХЭТ болон ОҮНБДНГ-ын багууд хөдөлгөөний эрхэм зорилгыг тодорхойлох. Тухайлбал, нэн түрүүнд анхаарах улсуудын жагсаалт гаргаж, мөн шаардагдах төслүүдийг боловсруулахдаа дэлхий дахинд хамгийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох. Ингэснээр төсөл тулгамдсан асуудлыг илүүтэй хөндөх болно.

- Оролцоонд түшиглэсэн төлөвлөлтийг ашиглах нь: ШУХЭТ баг нь оролцоонд түшиглэсэн төлөвлөлтийн аргыг ашиглан төслийн бусад талуудыг болон хувь хүмүүсийг хамтран болон бие биенийхээ төлөө ажиллах, ОҮНБДНГ эсвэл АНУ-ын ЭИ-ийн багаас хувь нэмрээ оруулахад нь анхаарах
- Туршилтын төслийн саналыг стандартжуулах: ШУХЭТ баг төслийн зорилго, зорилт, цаг хугацаа болон тооцоолсон үр дүнг тусгасан өргөдөл, хүсэлтийн хэлбэрийг тогтсон стандарттай болгох.
- Олон нийтийн эх сурвалж ашиглах бодлого, удирдамж боловсруулах: ЭИ нь кампанит ажил, хөдөлгөөний арга хэмжээнүүдэд эсвэл судалгаанд ашиглах зорилгоор олон нийтийн эх сурвалж бүхий мэдээллийг ашиглах удирдамж боловсруулах. Удирдамж нь ЭИ-ийн ёс зүйн хариуцлагыг, итгэл үнэмшлийг анхаарсан мөн тухайн мэдээллийн баталгаат байдлыг харгалзан үзсэн байх шаардлагатай.

#### **ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ, ХАРИЛЦАА ХОЛБОО БА ХАМТЫН АЖИЛЛАГАА**

- Удирдах зөвлөл: Удирдах зөвлөлийн гүйцэтгэх үүргийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Тус зөвлөл төслийг сонгохдоо стратегийн үүднээс хандах, хэрэв санал зөрөх тохиолдолд хэлэлцүүлэг хийх, шийдвэр гаргах үүргийг гүйцэтгэх.
- Харилцан ойлголцлын санамж бичиг: Энэхүү баримтыг туршилтын төсөлд хамрагдсан ажилтнуудтай хуваалцаж, тэднийг оролцуулах хэрэгтэй ба түүний зэрэгцээ төсөл болон ШУХЭТ төслийн багийн зөвлөх үйлчилгээг зохицуулах Үйлчилгээний Түвшний Хэлэлцээр (YTX) боловсруулах нь зүйтэй. YTX нь талуудын үүрэг, хариуцлага, баталсан хэлэлцээр түүний, гүйцэтгэлийн хуваарь зэргийг тодорхой болгох.
- Харилцаа холбоо: Удирдах зөвлөлд тайлагнах, мэдээлэх өмнөх туршлагагаа үргэлжлүүлэх. ШУХЭТ төслийн багийн ажлын явц, цаг хугацаа, үйл ажиллагаа шаардагдах талаар мэдэгдэж байх.
- Бичгэн баталгаа ба үр дүн: YTX-ийг ашигласнаар илрүүлж, цуглуулсан мэдээллийг танилцуулах талаар хэлэлцэх, батлах зэрэг үйл явцыг зохицуулахад тус нэмэр болно. Эцсийн шийдвэр гаргахаас өмнө урьдчилан хэлэлцэх.
- Төслийн менежмент: ШУХЭТ багт төсөл тус бүрийг хариуцсан удирдах хүн, арга барилыг тодорхойлох. Ингэснээр олон хүнтэй харьцах, хариуцлага тооцох зэрэг хүндрэлийг багасгах.
- Мэдлэгийн менежмент: ШУХЭТ төслийн баг мэдлэгийн менежментийн тогтолцоо боловсруулж, харилцаа холбоо, төслийн хэрэгжилтийн явц, үр дагавар, хяналт зэргийг бүгдийг баримтжуулсан эсэхийг баталгаажуулахад анхаарах.

#### **ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ БА ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СУРГАЛТ**

- Удирдлагын оролцоо: Эдгээр үйл ажиллагаанд зөвхөн судлаач, шинжээч болон кампанит ажлын зохицуулагчдыг оролцуулахаас гадна ЭИ-ийн удирдлагуудыг нэгтгэх нь чухал.
- Сургалт ба чадавхийг нэмэгдүүлэх нь: ОҮНБДНГ болон секцүүдэд тохиромжтой эх сурвалжид тулгуурласан сургалт явуулах. "Сансарын газар зүйн гарын авлага" хэмээх бүтээл хэрэгэлүүдийг тодорхойлж, тэднийг хэрхэн хэрэглэх талаар заадаг ба энэ нь цаашид ЭИ-ийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж болох ба ирээдүйд илүү өэрэг үр дүнд хүргэх магадлалтай. Түүнээс гадна ОҮНБДНГ-ын Судалгааны Арга зүйн хэсэгтэй хамтран ажиллаж, дээр дурдсан сансарын газар зүйн бүтээгдэхүүнийг судалгааны аргатай нэгтгэх.

#### **ХАРИУЦЛАГА, СУРГАЛТ БА ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ**

- Хяналт ба сургалт: Туршилтын төслийд ЭИ-ийн баримтладаг төслийн мөчлөгийн хувьд дагалдах төсөл хэлбэрээр хэрэгжинэ. Ил тод хяналтын тогтолцоо бий болгон үүрэг хариуцлагаыг харилцан тодорхойлж, ажилтнууд хянаргдсан баримт мэдээллийг цуглуулж, үнэлж дүгнэх.
- Мэдлэгийг түгээх нь: ШУХЭТ төслийн баг сансарын технологийг ашиглах талаархи зөвлөгөөг үргэлжлүүлэн бусад секцүүдэд танилцуулах хэрэгтэй. Холбогдох сэдвээр, эрдэм шинжилгээний чуулганд илтгэл тавьж, нийтлэл гаргах.
- Эзэмшсэн дадлага туршлагагаа шинэ төсөлд нэвтрүүлэх: ШУХЭТ баг өмнөх технологийн талаархи болон хамтын ажиллагаанаасаа суралцаж, эзэмшсэн дадлага туршлагагаа дараачийн төслийг санаачилахад ашиглах.
- Үнэлгээний үр дүнг түгээх: Үнэлгээний үр дүнг хэлэлцүүлэг хийх, суралцах зорилгоор хөдөлгөөнүүдэд хүртээмжтэй болгох хэрэгтэй.
- Шинжээчдийн төв: Даяар Менежментийн багаас ШУХЭТ төслийн багийг албан ёсоор шинжээчдийн төв болгон зөвшөөрөх талаар АНУ-ын ЭИ санал болгох. Ингэснээр үйл ажиллагааны үеэр сансарын газар зүйн технологийг ашиглах ажлыг дэмжих мөн шаардлагатай нөөц боломжоор хангахад туслалцаа үзүүлэх.

# ШИНХЛЭХ УХДАН ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЕСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖКҮЛЭН ТУРШИЛТЫН ТӨСЛҮҮД



Хиймэл дагуулын дурс  
төслийн  
зарын зураг  
ба судалгаа



Хиймэл дагуулын дурс  
төслийн  
боловсруулжтын шат




Хиймэл дагуулын дурс  
төслийн  
боловсруулжтын шат

## Кыргызстан

Кыргыз, Узбек залуучуудын хорондын зэвээт Мөргөлдөөнөөс үдэн 2010 оны б сарын 10-нд хүчирхийтэл эхлэсэн байна. Энэ мөргөлдөөн улам хурцаж, их хэмжээний санаатай талдан шатаэн, дээрэм тоонул, хүч хэрэглэн бусад хадлах, бэлтийн хадлагатай, мөн үзбек угээдийн онноор орчин сугаг Ош, Жапал-Абад болон эргэн тойрын тостонуудын их хэмжээнийтэй хяргдсан болжэ. Хамгийн багадаа 1,900 гаруй хүн хүнд гэмтэж эмнээгт хяргдсан дахи Кыргызийн судалгааны багтай хамтран ажилласнаар Шүхэт төслийн бац аласас мэдрэж төхөөрөмж байршуулж, энтийн иргэдийн эсрэг болон иргэний дэд бүтцийг сүйтгэж буй тохиолдуудыг баримтуулжсан байна.

## Пакистан

“Пакистаныг харах нуд төслө” нь Пакистаны баруун хойд хэсгэг ялангуяа эзгийн газрын удирддаг бусуд болон Баруун Хойд хязгаарын нутаг дахь хүний эрхийг нотцойгоор зөрчиж буй асуудалд хөндсөн зураг зүйн төслөл юм. Цахим худас гаргахас өмнө эй хүний эрхийн уламжлант судалгааны артыг ашиглан Талибаны зээгээт хүчиний болон Пакистаны эзгийн газраас явтуулж буй хохирлыг баримтжуулж байсан юм. Энэ төслийн мэдрэжлийн цэргийн ороодоо үзээр Эй-ийн дэлхийн хүний эрх нийт зөрчигдөх бий, бусийн талаар интэрактив, газрын зураг дээр түлгүүрласан мэдээлэл цүглүүлах эхийн оролдлого байсан байна.



## Дарфур

“Дарфурыг харах нуд” төслийг [www.yesesondarfur.org](http://www.yesesondarfur.org) цахим худасанд байршуулсан. Зэвсгэтийн хадлагын уеэр нүхж, сүйтгэдээн тостонуудын өмнөх болон одоогийн байдлыг харыгуулан харуулсан ондөр нягтрайтай хиймэл дагуулын дурсчүүдийг ашиглассан байна. Дурсээр тостон бус буриин хандлагын баримт мэдээллийг байршуулсан байсан. Нийтээ таван цахим худас газар дээр нь авсан газр зурагтнууд, үр дагаварын беримт, хэргийн бүртгэл болон хиймэл дагуулын дурсийг харуулсан байна. Үнээс тадна хоёр цахим худасанд газар дээр нь буулгасан дурс бичигт тавигжсан байна.

## Чад

Анг-ын ЭИ нь ОУНБДНГ дахи Чадын судалгааны багтай хамтран Н-Жаменагийн 2008 оны 1 сарыас 1 сар хүртэй хотын орон сууриндиг нурааж бүй баримт бүхий хиймэл дагуулар авсан дурсийг багалажуулж, шинжилж, ба 2010 оны шинэр авсан дурсчүүдийг тохиолдол гарсар байсан ба 2010 оны шинэр авсан дурсчүүдийг тохиолдол гарсар байсан камтланит ажил болон бусад Нөхөнгийн ажилдаа начнээлт материйн тараар ашиглажээ. Үүээс тадна ЭИ НДжаменад ажиллах хугацаандаа 2009, 2010 оны газар зүйн мэдээлэл шүгүүлжээ.

## ОХУ ба Гурж

Гурж, ОХУ-ын хорондын хүрцэдмал байдал 2008 онд зэвсэгт мөргөлдөөн хүргэх, Осгийн олон араван иргээдийг нүүгэн шилжүүлжэ. Зөрчилдлээс нутгийн бүс нутгийн дэд бүтцийг сүйгээн хотолгоо дүгнүүлэх зорилгоор Эй-ийн шинжээчид хамгийн ихээр хадлагдаг, өртөн хэсгийг тогтоож, өндөр нягтрайтай хиймэл дагуулын дурс зурагт авсан ба үүний дагуу Цинхвийл болон ойролцохи 24 тогтолын хэмжээд 2008 оны 8-р сарын 10-19-ийн хорондын зурагт дагуу чалж, тодорхойлжээ.

## Шри Ланк

2009 оны эхэр Шри Ланкийн Засгийн газрын турэмгийлийг зогсох үеэр, Шри Ланкийн зэвсэгт хүч Тамил Еламын Эрх Чөлөөний Баруудыг түрж, хижигчэн газарт аваачсан байна. Засгийн газрын цэргийн хүч удаа дарааллан бөмбөгдж, бусэсэн байна. 2009 оны бусалт газарт нэвтрэхийн түд 7000 гаруй энгийн иргэн агуулж, 13,000 иргэд гэмтсэн байна. Шүхэт багийнхан нэвтрэхэд хунддэгтэй энэ газрын талаар сансарын газар зүйн хэрэсэг ашиглан хиймэл дагуулын дурс, агаараас авсан зураг түглүүлахыг хийэжээ. Ялангуяа ЭИ гишүүд болон олон нийтийг хамрах үйл ажиллагаа баримт бичиг боловсруулж, бодит нотох харинтээр хиймэл дагуулар дамжуулан авах, тэднийн газар, широнгийн өрөө болгох ашигладаг чинчилэгийн хүчийн эрхийг холбоотой санаа зөвссөн асуудлуудар хэд хэдэн судалгааны чийгээний дэд цэг байжээ. Дарфуртай адилхан цахим худас гаргаж, хэрэгчэдчийн хүснүү судалгааны хайлт, мэдээлэл, сурталчилгааны, камтланит ажлудын материалын мөн Делта Нигерийн бүс нутгийн хүний эрхийн холбоотой асуудлын талаар мэдээлж авах боломжтой болосон байна.

## Эритрия

Эритрия дахи төслийн чадсан зорилго нь нүүч хорицгаар шоронгийн өрөө болгох ашигладаг чинчилэгийн хүчийн эрхийг холбоотой санаа зөвссөн асуудлуудар хэд хэдэн судалгааны чийгээний дэд цэг байжээ. Дарфуртай адилхан цахим худас гаргаж, хэрэгчэдчийн хүснүү судалгааны хайлт, мэдээлэл, сурталчилгааны, камтланит ажлудын материалын мөн Делта Нигерийн бүс нутгийн хүний эрхийн холбоотой асуудлын талаар мэдээлж авах боломжтой болосон байна.